

*“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт*

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

2020.12.21

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын дугаар	Шийдвэрийн агуулга	Хэрэгжилтийн явц	Гарсан үр дүн	нэлгээний хувь	Тасарсан болон удааширсан шалтгаан
1	2	3	4	5	6	7
<b>1.е.Засгийн газрын тогтоол</b>						
Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258	1.1.	Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх.	<p>Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг сахиулах арга хэмжээний хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, ажлаас хоцорсон, эрт тарсан болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цагаа дутуу бүртгүүлсэн ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцохдоо холбогдох журмын дагуу хасаж тооцож байна.</li> <li>- Сахилга хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан ажилтан, албан хаагчдын зөрчлийн талаарх мэдээллийг нээлттэй хүлээн авахын сацуу үйлчилгээний ажилтны ёс зүй, ажлын хариуцлагыг үнэлж, дүгнэх “Хяналтын хуудас” болон “Үнэлгээний карт” бөглүүлж байгаа болно.</li> </ul>	Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг чанд сахиулж, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх талаар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн үйл ажиллагааны онцлогтоо нийцүүлэн жил бүр шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2018 онд 17 ажилтан, албан хаагч, 2019 онд 11 ажилтан, албан хаагч, 2020 онд 8 ажилтан, албан хаагчид холбогдох сахилгын болон ёс зүйн зөрчил гарч, зөрчлийн тоо 2018 оноос 52,9%-иар, 2019 оноос 27,3%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.	100%	-

1	2	3	4	5	6	7
Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258			- Газрын даргын А/47 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ёс зүйн зөрчлийн мэдээг олон эх сурвалжаар нээлттэй хүлээн авч байна.			
	1.2.	Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх.	Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 3 эх сурвалжаар ирсэн нийт 184 өргөдлийг бүрэн шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн болон бичгээр хүргүүлсэн байна. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмол буурсан байна.	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 17 цаг 43 минут байгаа нь 2018 оны үзүүлэлтээс буурсан боловч 2019 оны үзүүлэлтээс өссөн дүнгээр харагдаж байгаа шалтгаан нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39.1-т заасан хугацааг баримтлах болсонтой холбоотой юм.	100%	-
	1.3.	Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах.	Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шуурхай арга хэмжээ авч, газрын даргын тушаалаар нийт ажилтан, албан хаагчдыг тусгайлсан цагийн горимд шилжүүлэн ажиллуулж, цахимаар ажиллах ажилтан, албан хаагчдын ажил үүргийг зөв жигд хуваарилан, төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг баримталж ажилласан.	Ажлын байрны чиг үүргийн давхцал үүсгэлгүйгээр ажлын ачааллыг зөв цэгцтэй хуваарилах, хөдөлмөрийн сахилгыг чанд сахиулж, ажлын бүтээмжийн нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд нийт 26 ажилтан, албан хаагчийг байгууллага дотор шилжүүлэн, 13 ажилтан, албан хаагчийг дэвшүүлэн томилж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хариуцлагыг	100%	-

1	2	3	4	5	6	7
Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258			Мөн үндэсний их баяр наадмын бэлтгэл ажил, Монгол улсын төв цэг гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа, бусад цаг үеийн шинж чанартай үйл ажиллагаа, арга хэмжээний үеэр ажилтан, албан хаагчдын ажлын цагийг зөв зохион байгуулж, ажлын ачааллыг жигд хуваарилан, ажлын байрны давхардал хийдэл үүсгэхгүй, нэг ажилтанд хэт их ачаалал өгөхгүй байхад тогтмол анхаарч ажиллаж байна.	нэмэгдүүлэх, чиг үүргийг жигд зөв хуваарилах арга хэмжээ авч ажиллалаа.		
	1.4.	Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж, албан хаагчийн ажлын ур чадвар, дадлага туршлага, ёс зүй, харилцаа хандлага, мэдлэг боловсрол зэрэг үзүүлэлтийг харгалзан дэвшүүлэн томилж байна. Тайлант хугацаанд тооцооны нягтлан бодогч Х.Бямбанаранг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогчоор, зоогийн газрын зөөгч Д.Оюунтуяа, угтах үйлчилгээний ажилтан А.Нямсүрэн нарыг байр хариуцсан менежерээр, тоног төхөөрөмж хариуцсан техникч Б.Эрдэнэтөгсийг зоогийн газрын менежерээр, зоогийн газрын касс Г.Мөнхцэцэгийг үндсэн хөрөнгө, бараа материалын нярваар, бэлтгэгч тогооч Б.Буян-Эрдэнийг тогоочоор зэрэг нийт 13 ажилтан, албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна.	Ажилтан, албан хаагчдыг байгууллага дотор дэвшүүлэн томилох болсноор тэдгээрийн идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээ цуцлах байдал буурсан байна. Тодруулбал: 2018 онд нийт 289 ажилтан, албан хаагчаас 48 буюу 16,6%, 2019 онд нийт 300 ажилтан, албан хаагчаас 28 буюу 9,68%, 2020 онд нийт 300 ажилтан, албан хаагчаас 30 буюу 10% нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан байх ба энэ тоог байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын тоонд харьцуулан дүгнэвэл 0.11-0.13%-иар буурсан байна.	100%	-

1	2	3	4	5	6	7
	1.5	Төрийн захиргааны болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2019.09.01-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох.	Манай байгууллага нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарах бөгөөд төрийн албыг түр орлон гүйцэтгэж буй орон тоо байхгүй болно.		Үнэлгээгүй ажил	Хяналтаас хасуулах саналтай.
	1.6.	Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх.	Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 26 ажилтан албан хаагч, хувийн болон эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 6 албан хаагч, нийт 32 ажилтан албан хаагчийн ажлын байрны сул орон тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.	Манай байгууллага нь хуульд заасан үндэслэлээр урт хугацааны чөлөөтэй байгаа 32 ажилтан, албан хаагчийн сул орон тоонд ажиллаж буй ажилтантай хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бусад шалтгаанаар гэрээт ажилтан ажиллуулдаггүй болно.	100%	-

1	2	3	4	5	6	7
Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258	1.7.	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох	Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 8 удаа хуралдаж 7 ажилтан, албан хаагчид холбогдох асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнээс 2 ажилтан, албан хаагчид холбогдох ёс зүйн зөрчил тогтоогдож сануулах арга хэмжээ авсан байна. Мөн сахилгийн зөрчилтэй холбоотой 5 зөрчлийг шалгаж, 2 ажилтан, албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1, 131.1.3-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулсан.	Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг чанд сахиулж, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх талаар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн үйл ажиллагааны онцлогтоо нийцүүлэн жил бүр шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2018 онд 17 ажилтан, албан хаагч, 2019 онд 11 ажилтан, албан хаагч, 2020 онд 7 ажилтан, албан хаагчид холбогдох сахилгын болон ёс зүйн зөрчил гарч, зөрчлийн тоо 2018 оноос 52,9%-иар, 2019 оноос 27,3%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.	100%	-
	1.8.	Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажлууд хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр 2 удаа, харилцаа хандлагын чиглэлээр 3 удаа сургалт зохион байгуулж, ажилтан, албан хаагчдаа хамруулсан.	Сургалт, нийгмийн ажлын үр дүнд ёс зүйн зөрчил жил бүр буурч буй нь 1.7-д заасан үүрэг даалгаврын үр дүн хэсгээс харагдана.	100%	-
	1.10.	Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож,	Газрын хөдөлмөрийн дотоод журам болон ёс зүйн дүрэмд ажилтан, албан хаагчид бие биенээ ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалттай	Тайлант хугацаанд ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, ялгаварлан гадуурхсан үйлдлийн талаар	100%	-

1	2	3	4	5	6	7
Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258		ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах	бөгөөд уг үйлдлийг удаа дараа гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас халах хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан болно.	ажилтан, албан хаагчаас гомдол санал ирээгүй байна.		-
	3.	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд дараах чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээний ажил хийлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээ;</li> <li>- Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа;</li> <li>- НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал, халдваргүйжүүлэлт;</li> <li>- Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаанд 4 удаа;</li> <li>- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлт.</li> </ul> Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд нийт 63 зөвлөмж боловсруулан хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг газрын даргад танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох албан хаагчдад өгч, үүрэг даалгаврын хэрэгжилтийг буцаан тайлагнаж, эргэх холбоог үүсгэн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлын төлөвлөгөөний биелэлт тайлан гаргасан өдрийн байдлаар 95 хувийн хэрэгжилттэй байна.	95%	-

1	2	3	4	5	6	7
<p>Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020.02.12 № 2020_62</p>	<p>3.</p>	<p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.</p>	<p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар болон Баянхошуу дэд төвийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлж, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, хяналт тавин ажилласан.</li> <li>- Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллах талаар зөвлөмж өгч, үйлчилгээний ажилтнуудад нэг удаагийн бээлий, малгай, хувцас, амны хаалт зэрэг хэрэгслийг олгосон.</li> <li>- Халдвараас урьдчилан сэргийлэх цаасан зөвлөмжийг НЗЗ-ны байруудын нийтийн эзэмшлийн талбайд байршуулан, дэлгэцээр халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөөг видео хэлбэрээр нийтэд хүргэж ажиллав.</li> <li>- Мөн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан ажлын тусгай горимд шилжүүлэх, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” газрын даргын 2020 оны А/14 дүгээр тушаалын дагуу албан хаагчид Хан-Уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт эргүүлээр ажиллаж иргэд болон тус хороонд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд шинэ коронавирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар санамж, зөвлөмжүүдийг хүргэж ажилласан болно.</li> </ul>	<p>Коронавируст /Ковид-19/ халдварт өвчнөөс сэргийлэх, тархалтын хүрээг өргөжүүлэхгүй байх зорилгоор тайлант хугацаанд нийт 250 гаруй ажилтан, албан хаагчид Хан-Уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт өдрийн хоёр ээлжээр эргүүлээр ажиллаж, давхардсан тоогоор 15.000 орчим иргэдэд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх шаардлага тавьж, зөвлөмж өгсөн. Мөн 850 орчим аж ахуйн нэгжүүдэд амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, гадна орчны цэвэрлэгээг тогтмол хийх, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулан ажиллалаа. Түүнчлэн ажилтан, албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллах заавар зөвлөмж тогтмол өгч, шаардлагатай ажлын хувцас хэрэгсэл олгон ажилласнаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зөрчил гараагүй болно.</p>	<p>100%</p>	<p>-</p>

1	2	3	4	5	6	7
<p>Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020.03.22 № 2020_102</p>	<p>4.</p>	<p>Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай.</p>	<p>Коронавируст /ковид-19/ цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд цэвэрлэгээ үйлчилгээндээ онцгой анхаарч ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэн, байруудын гадна болон дотор орчныг ариутгаж, халдваргүйжүүлсэн. Мөн байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийн нэмэгдүүлэн гарын шингэн саван, гар ариутгагч гел байршуулсан. Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд болон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн гадна талбайн өдөр тутмын цэвэрлэгээг 50 метр хүртэлх орчинд тогтмол хийж, цас орсон өдрүүдэд байр ашиглалтын албаны ажилтнууд нэмэлтээр ажиллаж, техник хэрэгслийн тусламжтайгаар гадна талбайн цас, мөсийг тухайн бүр арилгаж байна.</p>	<p>Коронавируст /ковид-19/ цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд цэвэрлэгээ үйлчилгээндээ онцгой анхаарч ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэн, байруудын гадна болон дотор орчны 41.636 м.кв талбайд өдөр бүр ариутгал, халдваргүйжүүлэлт хийж ажилласан.</p>	<p>100%</p>	<p>-</p>
<p>Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2020.11.04 № 2020_171</p>	<p>1.</p>	<p>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор энэ онд Шинэ жилийн баярыг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарласугай.</p>	<p>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих үүднээс бүх нийтийн бэлэн байдлын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийтийг хамарсан аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах, шинэ жилийг тэмдэглэн өнгөрүүлэхийг хориглосон болно.</p>	<p>Засгийн газрын 2020 оны 171, 178 дугаар захирамж гарсантай холбогдуулан тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд нийтийн хамарсан аливаа үйл ажиллагаа, аргаа хэмжээ зохион байгуулаагүй бөгөөд зайлшгүй шаардлагаар хийгдэх сургалт болон хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байна.</p>	<p>100%</p>	<p>-</p>



1	2	3	4	5	6	7
<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020.11.18 № 2020_183</p>	<p>23.</p>	<p>Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, соён гэгээрүүлж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэг, контентыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, нэвтрүүлэх, хүн хооронд 2 метрийн зай барих, амны хаалт тогтмол зүүлгэх, үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, ариутгах бодисыг байршуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх ажлыг зохион байгуулж байхыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Соёлын сайд С.Чулуун, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян) болон холбогдох бусад албан тушаалтанд даалгасугай.</p>	<p>Газрын даргын А/62, А/63 дугаар тушаалын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хатуу хөл хорионы дэглэм тогтоосон үед ажлын хариуцлагыг өндөржүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг чангатгах үүднээс дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор биеийн халууныг тогтмол үзэж нэвтрүүлэх, гарыг ариутгах, амны хаалтыг зөв зүүж үйлчлүүлэх шаардлагыг тавьж ажилласан.</li> <li>- Байгууллагуудаас ирүүлсэн нэрсийн жагсаалттай албан хаагчдын ажлын үнэмлэхийг тулгаж шалгах, иргэний үнэмлэхийн QR кодыг уншуулж бүртгэх ажлыг зохион байгууллаа.</li> <li>- Нийслэлийн засаг захиргааны 1 болон 2 дугаар байрны үүдэнд биеийн халууныг үзэж, уураар ариутгах төхөөрөмж, механик ажиллагаатай гар ариутгагч тус тус байршуулсан.</li> <li>- Байруудын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.</li> <li>- Нийт ажилтан, албан хаагчид ажлын тусгай горимд шилжин ажиллаж, цагийн бүртгэлийн UB ERP цахим системээр бүртгүүлсэн болно.</li> </ul>	<p>Газрын даргын А/61 дүгээр тушаалаар баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу бэлтгэсэн мэдээгээр долоо хоног бүр давхардсан тоогоор нийслэлийн засаг захиргааны байруудаар 5000 гаруй хүн нэвтэрсэн ба бүртгэл хийх явцад зөрчил доголдол гараагүй болно. Мөн Засгийн газрын 181 дүгээр тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд нийслэлийн засаг захиргааны 5-н байраар нэвтэрсэн давхардсан тоогоор 10,000 гаруй хүнийг иргэний үнэмлэхийн QR кодоор бүртгэлжүүлсэн байна.</p>	<p>100%</p>	<p>-</p>
		<p>Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын</p>	<p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээний дагуу</p>	<p>Нийслэл хотын хэмжээнд бэлэн байдлын зэрэгт</p>		

1	2	3	4	5	6	7
<p>Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2020.11.29 № 2020_194</p>	<p>4.</p>	<p>зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.</p>	<p>дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар, дэд төвүүдийн нийтийн эзэмшлийн 9549.6 м.кв талбай, ажлын өрөөний 28,113.5 м.кв, нийт 420,09.1 м.кв талбайд цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг 2 цаг тутамд, байруудын гадна талбайн өдөр тутмын цэвэрлэгээг 50 метр хүртэлх орчинд тогтмол хийж байна.</li> <li>- Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг өөрийн оршин суух дүүрэг, хороонд харьяаллын дагуу коронавирусийн PCR шинжилгээнд хамрагдах үүрэг чиглэл өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна.</li> <li>- Цар тахлын халдвараас ажилтан, албан хаагчид, үйлчлүүлэгчдийг хамгаалах үүднээс үйлчилгээний ажиллагсдад хамгаалалтын хэрэгсэл нэг удаагийн амны хаалт, бээлий, малгай, хамгаалалтын хувцас, ариутгагч спирт, гар ариутгагч гел, халуун хэмжигч төхөөрөмж, халдваргүйжүүлэлтийн бодис зэрэг халдвар хамгааллыг хэрэгслийг тухай бүр шаардах хуудсаар олгож байна.</li> </ul>	<p>шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан холбогдох арга хэмжээг шуурхай авч ажилласнаар тайлант хугацаанд дараах ажлын үр дүн гарсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, дэд төвүүдийн нийт 420,09.1 м.кв талбайд цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг 2 цаг тутамд хийж хэвшсэн.</li> <li>- 2020.12.18-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 277 ажилтан, албан хаагч коронавирусийн PCR шинжилгээнд хамрагдсан байна.</li> <li>- Ажилтан, албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд нь зайлшгүй шаардагдах хамгаалалтын хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг шуурхай олгож, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.</li> </ul>	<p>100%</p>	<p>-</p>
	<p>7.</p>	<p>Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн</p>	<p>Газрын даргын 2020 оны А/61 дүгээр тушаалаар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж болон хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, байгууллагын</p>	<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 7 хоног бүр нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан, цар</p>	<p>100%</p>	

1	2	3	4	5	6	7
		<p>байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.</p>	<p>хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Газрын даргын А/62 дугаар тушаалаар зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд ажилтан, албан хаагчдыг цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба ийнхүү ажиллуулахдаа төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг баримталж байна.</p> <p>Газрын даргын А/64 дүгээр тушаалаар томилогдсон “Шуурхай баг” 24 цагаар ээлжлэн ажиллаж, байруудын инженерийн байгууламжийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.</p> <p>Мөн газрын даргын А/06 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн зарлан мэдээлэх схемийг батлах тухай” тушаалыг албан хаагчдад тарааж, гамшгаас хамгаалах, зарлан мэдээлэх схемийн бэлэн байдлыг ханган ажиллаж байгаа болно.</p>	<p>тахлын эсрэг хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Байгууллагын албан хаагчдад цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэн “Цахимаар ажиллах түр журам” боловсруулан мөрдөж байна.</p>		
Хэсгийн дундаж: 99,68 хувь						

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ХОРОЛДУЛАМ